



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 02 өдөр

Дугаар Ж/12

Баян-Овоо сум

А.Эрдэнэтуяаг ажилд томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт (сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ), Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 224 дүгээр тогтоолын 1 дэх заалт (шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай), 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 491 дүгээр тогтоол (төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам), Боловсролын сайдын 2026 оны 01 сарын 26-ны өдрийн А/20 тушаал (Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай)-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Алтаннавчийн Эрдэнэтуяагийн жирэмсний болон амаржсаны амралт дууссан тул өөрийн хүсэлтийг үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс нийгмийн ажилтны үүрэгт ажилд томилсугай.

2. Нийгмийн ажилтан А.Эрдэнэтуяагийн сарын үндсэн цалинг ТҮБД-4 зэрэглэлээр тогтоон 2,338,500 (хоёр сая гурван зуун гучин найман мянга таван зуу) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 8 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг А.Эрдэнэтуяаг үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  Ч.БОЛОРМАА



2326010035